

## ХААН БАНК ХК-ИЙН 2024 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

ХААН Банк нь 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 19-ний өдрийн хооронд олон нийтэд 959 төгрөгийн нэгж үнэ бүхий 191,219,800 ширхэг энгийн хувьцааг санал болгох замаар нийт 183,379,788,200.00 (Нэг зуун наян гурван тэрбум гурван зуун далан есөн сая долоон зуун наян найман мянга хоёр зуун) төгрөгийг татан төвлөрүүлсэн болно.

Тус Банк нь энгийн хувьцааг нийтэд санал болгон арилжсанаар өөрийн хөрөнгөө нэмэгдүүлснээс гадна татан төвлөрүүлэх хөрөнгийн 16 хувийг банкны бүтээгдэхүүн үйлчилгээний цахим шилжилтийг хурдасгах мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтад, 19 хувийг цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, шинэчлэлтэд, 34 хувийг ногоон төсөл хөтөлбөрүүдэд болон 31 хувийг урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээл, орон сууцны зээл санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн.

Мөн дунд хугацаанд харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, зайнаас хүргэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвараа сайжруулахад чиглэсэн цахим шилжилтийн зорилтуудаа хэрэгжүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа хадгалах, тэлэх зорилтуудыг дэвшүүлсэн.

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

(төгрөгөөр)

Д/Д	Зарцуулалтын төрөл	Эзлэх хувь	ТТХ дүн	Нийт зарцуулалт (2023.II - 2024.I)	Эх үүсвэрийн үлдэгдэл
1	Мэдээллийн технологийн хөрөнгө оруулалт	16%	29.3 тэрбум	28.3 тэрбум	1.0 тэрбум
2	Цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, сайжруулалт	19%	34.8 тэрбум	29.2 тэрбум	5.6 тэрбум
3	Ногоон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт	34%	62.4 тэрбум	62.4 тэрбум	0
4	Урт хугацаат зээл /Орон сууц, хөрөнгө оруулалтын санхүүжилт/	31%	56.9 тэрбум	56.9 тэрбум	0
	Нийт	100%	183.4 тэрбум	176.8 тэрбум	6.6 тэрбум

- ХААН Банк нь 2023 оны 4 дүгээр сард Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлснээс хойш үйл ажиллагаагаа сайжруулахаар мэдээллийн технологийн чиглэлээр идэвхтэй хөрөнгө оруулсаар байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд энэ чиглэлээр нийт 28.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулаад байна. Үүнд Үүлэн технологийн шинэчлэлтэд 4.3 тэрбум төгрөг, Өгөгдлийн хадгалалт, технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 5.0 тэрбум төгрөгийг зарцуулсан бол банк даяарх Дижитал шилжилтийн хүрээнд 13.9 тэрбум төгрөгийг тус тус зарцуулаад байна. Мөн Цахим аюулгүй байдал болон банкны дотоод процессын автоматжуулалтуудын төслүүдэд 5.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулаад байна.
- Тус Банк нь харилцагч, карт эзэмшигчдэдээ амар хялбар, хурдан шуурхай, нууцлалын өндөр түвшин бүхий орчин үеийн техник технологид суурилсан бэлэн бус төлбөр тооцооны үйлчилгээг хүргэдэг. Үүнийг тогтмол сайжруулан, харилцагчдынхаа сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулан хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, сайжруулалтад татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 34.8 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 2024 оны 03 дугаар сарын 31-ний байдлаар 29.2 тэрбум төгрөг зарцуулсан байна.
- Ногоон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтэд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 62.4 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн. Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн хүрээнд ХААН Банк барилгын дулаан алдагдал, эрчим хүчний хэрэглээнээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмрээ оруулах зорилгоор тусгайлан зээлийн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлж, тэдгээр зээлүүдийг санхүүжүүлэхээр ажиллаж байна. Бид эрчим хүчний хэмнэлттэй барилгыг санхүүжүүлэх, гэр хороолол, зуслангийн бүсэд амьдарч буй иргэдийн амьдрах орчноо сайжруулахад чиглэсэн урт хугацаат, таатай нөхцөл бүхий ногоон зээлийн бүтээгдэхүүнийг гарган зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд 2024 оны 1-р улирлын байдлаар тус хөрөнгийг 100% буюу бүрэн зарцуулсан байна.
- Иргэдийн орон сууцны зээл болон бизнесийн урт хугацаат хөрөнгө оруулалтын зээлийн олголтод татан төвлөрүүлсэн хөрөнгийн 56.9 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 2023 оны 2-р улиралд тус хөрөнгийг 100 хувь буюу бүрэн зарцуулсан байна.